

## БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨГЖЛИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЯЛГАА, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Цэдэв-Иш Отгонхүү

ШУА-ын Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Нийгэм эдийн засгийн салбар

Ts.otgonkhuu@gmail.com

**Abstract.** The main propose of this article analyses the territorial differentiation of the educational service developments and to cultivate aggregative methodology. What factor that can be affect for the educational service developments. Results of this research we estimated by index of territorial differentiation of educational service in Central part of Mongolia such as 13 provinces and 194 soum (smallest administration unit of Mongolia) level and examine what factor that can be affect for the educational service developments.

**Key words:** educational service, territorial differentiation, index, factor, educational service developments

### ОРШИЛ

Дэлхийн 2014 оны хүний хөгжлийн илтгэлд мэдээлснээр Монгол улс хүний хөгжлөөрөө дунд түвшинд байгаа улсуудын тоонд багтаж 103-р байрт жагсаж байна. Дэлхийн хүний хөгжлийн илтгэлд нэг хүнд ногдох үндэсний нийт орлого, дундаж наслалт, боловсролын индексийг ашиглан тооцдог [1]. Дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшинг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь хүний хөгжлийн индекс. Хүний хөгжлийн индексийг тодорхойлдог гол үзүүлэлтүүдийн нэг нь боловсролын индекс. Ийм учраас дэлхийн улс орнууд ард иргэддээ чанартай, хүртээмжтэй боловсролыг адил тэгш эзэмшүүлэхийг зорисоор ирсэн.

Харин манай орны хувьд боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин нутаг дэвсгэрийн хувьд ялгаатай байна. Тухайлбал: 2012-2013 оны хичээлийн жилийн байдлаар Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 5-р сургуульд 56 бүлгийн 2160 хүүхэд суралцаж, бүлэг дүүргэлт 38,5 байхад Төв аймгийн Сэргэлэн сумын сургуульд 8 бүлгийн 43 хүүхэд суралцаж, бүлэг дүүргэлт 5,3 байгаагаас харагдаж байна [2]. Үүнээс шалтгаалан боловсролын үйлчилгээний нутаг дэвсгэрийн ялгааг тогтоох, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх судалгааны нэгдсэн аргазүй боловсруулах, шинжлэх ухааны

үндэслэлтэй аргазүйгээр хийгдсэн судалгааны ажил шаардлагатай байгааг анзаарч энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

### СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Монгол орны үйлчилгээний газарзүйн судалгааны талаар дорвитой томоохон судалгаа хийгдэж байгаагүй боловч ШУА-н Газарзүйн хүрээлэнгийн Нийгэм эдийн засгийн газарзүйн секторт С.Гэрэлээ анхлан судалгаа явуулж эхэлжээ. Тэрээр үйлчилгээний газарзүйн тойргийг Монгол орны нөхцөлд тохируулан гаргаж ирэхийг зорьсон бол О.Сүхбаатар, М.Нямбуу нар үйлчилгээний газарзүйн тодорхой чиглэлээр судалгаа явуулж байжээ. Үйлчилгээний газарзүйн талаар судалгаа явуулсан өмнөх судлаачдын судалгааны материалыг үзэхэд Монгол орны нөхцөлд тохирсон үйлчилгээний газарзүйн салбарын дараахь хувилбарыг гаргаж байжээ [3]. Үүнд:

- Соёлын
- Боловсролын
- Эмнэлгийн
- Ахуйн үйлчилгээ
- Рекреаци гэсэн таван үндсэн хэлбэрт хуваажээ.

Өнөө үед материаллаг үйлдвэрлэлээсээ илүү хурдацтай хөгжиж байгаа үйлчилгээний салбарын бүтцийн ангиллыг 2012 онд М.Баянтөр гаргасан байна [4]. Үүнд:

- Аж ахуйн үйлчилгээ (Тээвэр, нийтийн аж ахуй, байшин барилга барих, засварлах, техник тоног төхөөрөмжийг ажиллуулахтай холбогдсон үйлчилгээ)
- Нийгмийн үйлчилгээ (Соёл, боловсрол, эрүүл мэндтэй холбогдсон үйлчилгээ)
- Ажил хэргийн үйлчилгээ (Удирдлага, зөвлөгөө өгөх, хүний нөөцтэй холбогдсон үйлчилгээ)
- Хувь хүнд үзүүлэх үйлчилгээ (үсчин, цэвэрлэгээ, зочид буудал, гуанз, ресторан, дэлгүүр ... г.м)

гэсэн үндсэн дөрвөн хэлбэрт хуваажээ.

Эдгээр судлаачдын бүтээлээс харахад боловсролын үйлчилгээ бол үйлчилгээний гол салбарын нэг болох нь харагдаж байна. Бид боловсролын үйлчилгээний хөгжлийн нутаг дэвсгэрийн ялгааг илэрхийлэх нэгдсэн индекс, түүнийг тооцох аргазүй боловсруулахыг гол зорилгоо болгож, үүний тулд эхлээд индекс тооцоход ашиглагдах боломжтой шалгуур үзүүлэлтүүдийг тогтоосон.

Дэлхийн улс орнуудын хөгжлийг тодорхойлдог гол индексүүдэд боловсролын үзүүлэлтүүдийг заавал оруулан тооцсон байдаг. Тухайлбал: Хүний хөгжлийн индекс болон Орон нутгийн хөгжлийн индекс, Мянганы хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд зэрэгт боловсролын дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан (Зураг 1) байна.

Манай улсад Нэгдсэн үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас 2009 оны 11-р сард баталсан боловсролын үзүүлэлтүүдийг тооцох “Техникийн гарын авлага”-д үндэслэсэн Үндэсний статистикийн хорооноос боловсруулсан

“Боловсролын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-д 4-н бүлгийн 42 шалгуур үзүүлэлтийг тооцож байна [5]. Үүнд:

1. Боловсролын хүртээмжийн үзүүлэлтүүд -10
2. Боловсролын дотоод үр ашгийн үзүүлэлтүүд - 9
3. Боловсролын үр дүнгийн үзүүлэлтүүд - 13
4. Боловсролын салбарын зардал, хүний нөөцийн үзүүлэлтүүд - 10

Боловсролын статистик үзүүлэлтүүдийг тооцох аргачлалд тусгагдсан 42 шалгуур үзүүлэлтийн эх сурвалж нь БШУЯ, ҮСХ болон Хүн ам, орон сууцны улсын тооллого байх бөгөөд улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд 29 үзүүлэлтийг тооцох боломжтойгоос 25 үзүүлэлтийг жил бүр тооцох боломжтой байна. Харин дөрвөн үзүүлэлт нь хүн ам, орон сууцны тооллогын материалаас гардаг учир 10 жил тутамд тооцох боломжтой. Үлдсэн 13 үзүүлэлтийн зургааг нь зөвхөн улсын түвшинд жил бүр, долоог нь зөвхөн аймаг, нийслэлийн түвшинд жил бүр тооцох боломжтой байна.

<p><b>ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургуульд суралцсан дундаж хугацаа</li> <li>• Сургуульд суралцах хугацаа</li> </ul>	<p><b>МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин</li> <li>• Нэгдүгээр ангид элсэгчдийн хувь</li> <li>• 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь</li> </ul>	<p><b>ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж гэсэн бүлэгт нийт 10</li> </ul>
--	--	--

Зураг 1. Зарим индексүүдэд ашигласан боловсролын үзүүлэлтүүд

Боловсролын үйлчилгээний хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо ҮСХ-ны “Боловсролын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”-д тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийг Хүний хөгжлийн индекс, Мянганы хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд, Орон нутгийн хөгжлийн индекс, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийх журам зэрэг индексүүдэд ашиглагдсан байдлыг харгалзан сонгосон.

Боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс тооцохдоо шалгуур үзүүлэлт тус бүрийн утгаар Монгол орны төв хэсгийн 13-н аймгийн 194 сумдыг 5 бүлэг болгон ангилж сайн үзүүлэлтгэйд нь их оноо өгөх замаар үнэлгээ өгч нийт оноог гаргасан. Нийт оноогоор 194 сумыг эрэмбэлж дараахь нэгдсэн томъёогоор сум тус бүрийн боловсролын үйлчилгээний хөгжлийн индексийг тооцон гаргасан.

$$\text{Индекс} = \frac{\text{Бодит утга} - \text{Хамгийн бага утга}}{\text{Хамгийн их утга} - \text{Хамгийн бага утга}}$$

Боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс нь тухайн сумын боловсролын үйлчилгээний хөгжил бусад сумдтай харьцуулахад ямар байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс өндөр байна гэдэг нь тухайн сум боловсролын үйлчилгээний хөгжил сайтай гэхээсээ илүү бусад сумдтай харьцуулахад боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин илүү гэж ойлгох нь зөв юм.

Мөн бид энэхүү судалгаандаа боловсролын үйлчилгээний нутаг дэвсгэрийн ялгааг илэрхийлэх нэгдсэн индексийг тогтоосны үндсэн дээр түүнд нөлөөлж буй газарзүйн хүчин зүйлсийг тодорхойлох зорилтыг давхар тавьсан юм. Энэ талаар судалгаа явуулсан өмнөх судлаачдын бүтээлээс харахад ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн Нийгэм эдийн засгийн газарзүйн секторт С.Гэрэлээ анхлан судалгаа хийж боловсролын үйлчилгээний тойргын хөгжилд дараахь хүчин зүйлс гол нөлөөтэйг дурьдсан байна [6]. Үүнд:

1. Хөдөөгийн байнгын суурингууд буюу сумын төвүүдийн байршилт, хоорондын зай
2. Дэд бүтцийн хангамж, зам тээврийн нөхцөл
3. Хүн амын байршилт, нутагшилт
4. Байгаль-газарзүйн нөхцөл зэргээс хамаарна гэжээ.

Мөн ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн Нийгэм, эдийн засгийн газарзүйн секторын 2008-2010 оны “Монгол улсын нийгэм, эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх газарзүйн үндэслэл” сэдэвт ажлын хүрээнд хот суурингийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чадавхийг тодорхойлох оролдлого хийж түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тайлбарласан [7]. Үүнд:


1. Хүн амын тоо
2. Аймгийн төвөөс алслагдсан зай
3. Тэнхлэгээс алслагдсан зай гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан байна.

Үүнээс үндэслэн бид судалгаандаа боловсролын үйлчилгээний нутаг дэвсгэрийн ялгаатай байдалд нөлөөлж буй дараахь хүчин зүйлсийг сонгож дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

1. Аймгийн төвөөс алслагдсан байдал
2. Сумын хүн амын тоо
3. Хатуу хучилттай замын нөлөөлөл

Судалгаанд хамрагдсан нутгийн тойм

Энэхүү судалгаанд Монгол орны төв хэсгийн 13-н аймгийн 194 сум хамрагдсан



Зураг 2. Боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс

бөгөөд энэ нь манай орны нийт сумдын 58,61 хувь болж байна. Эдгээр сумдыг дээрхи аргачлалын дагуу боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшинг тооцоолж үзэхэд судалгаанд хамрагдсан нийт сумдын 15,98 хувь буюу 31 сум нь маш дээгүүр ангилалд, 28,87 хувь буюу 56 сум нь дээгүүр ангилалд, 32,47 хувь буюу 63 сум нь дундаж ангилалд, 16,49 хувь буюу 32 сум нь доогуур ангилалд 6,19 хувь буюу 12 сум нь маш доогуур ангилалд ангилагдаж (Зураг 2) байна.

[Аймгийн төвтэй ойролцоо сумдын (40 хүртэлх км) сумын төвүүд нь боловсролын үйлчилгээний үүргээ аймгийн төвдөө алдаж байна.]

Судалгаанд хамрагдсан бүс нутагт харьяалагдаж байгаа нийт 13 аймгийн 194 сумдыг аймгийн төвөөс алслагдсан зайн шатлалаар ангилахад нийт сумдын 6,07 хувь нь аймгийн төвийн, 8,24 хувь нь аймгийн төвөөс 0-40 км-ын зайн шатлалд, 23,19 хувь нь аймгийн төвөөс 40-100 км-ын зайн шатлалд, 61,85 хувь нь аймгийн төвөөс 100-аас дээш км-ын зайн шатлалд тус тус хамрагдаж байна. Аймгийн төвийн 13-н сумыг боловсролын үйлчилгээний хөгжлийн индексээр нь ангилахад 92,31 хувь нь маш дээгүүр

үзүүлэлттэйд хамрагдаж байна. Харин аймгийн төвөөс 40 хүртэлх км-ын зайн шатлалд харьяалагдаж байгаа 16 сумдыг боловсролын үйлчилгээний хөгжлийн индексээр ангилахад 6,25 хувь нь дээгүүр, 18,75 хувь нь дундаж, 37,5 хувь нь доогуур, 37,5 хувь нь маш доогуур ангилалд багтаж байна. Мөн аймгийн төвөөс 40 хүртэл км-ын зайн шатлалд

хамрагдаж байгаа сумдын 78,94 хувь нь боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс дундаж болон түүнээс доош ангилалд хамрагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл аймгийн төвөөс 40 хүртэлх км зайд алслагдсан сумдын боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин доогуур (Хүснэгт 1) байна.

Хүснэгт 1. Боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс, аймгийн төвөөс алслагдсан зайн шатлалаар, 2013 он

Аймгийн төвөөс алслагдсан зайн шатлал	Маш доогуур (0,000-0,200)		Доогуур (0,201-0,400)		Дундаж (0,401-0,600)		Дээгүүр (0,601-0,800)		Маш дээгүүр (0,801-1,000)		Нийт
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
Аймгийн төв	0	0,00	0	0,00	0	0,00	1	7,69	12	92,31	13
0-40 км	6	37,50	6	37,50	3	18,75	1	6,25	0	0,00	16
40-100 км	2	4,44	13	28,89	17	37,78	11	24,44	2	4,44	45
100-аас дээш км	4	3,33	13	10,83	43	35,83	43	35,83	17	14,17	120
Нийт	12	6,19	32	16,49	63	32,47	56	28,87	31	15,98	194

Эх сурвалж: Аймгуудын статистикийн товчоон, 2013

Тухайлбал: Аймгийн төвөөсөө 22 км зайтай Булган аймгийн Орхон сумын боловсролын үйлчилгээний зарим үзүүлэлтүүдээс харахад ерөнхий боловсролын сургуульд сурах насны 3 хүүхэд тутмын 2 нь, 1-р ангид элсэх насны 4 хүүхэд тутмын 3 нь аймгийн төвийн

сургуулиудад боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Мөн аймгийн төвөөсөө 25 км зайтай Өмнөговь аймгийн Ханхонгор сумын сургуулийн насны 2 хүүхэд тутмын 1 нь, 1-р ангид элсэх насны 5 хүүхэд тутмын 4 нь аймгийн төвдөө сургуульд сурч (Хүснэгт 2) байна.

Хүснэгт 2. Аймгийн төвтэй ойролцоо сумдын боловсролын үйлчилгээний зарим үзүүлэлт, 2010 он

Аймаг, сумын нэр	Аймгийн төвөөс алслагдсан зай, км-ээр	ЕБ-ын сургуулийн хамран сургалтын бохир жин			1-р ангид элсэгчдийн хамран сургалтын бохир жин		
		2010 он	2013 он	Зөрүү	2010 он	2013 он	Зөрүү
Булган, Орхон	22	29,20	29,18	-0,02	36,67	25,00	-11,67
Өмнөговь, Ханхонгор	25	48,46	40,82	-7,64	40,54	20,45	-20,09

Эх сурвалж: Аймгуудын статистикийн товчоон, 2013

Аймгийн төвтэй ойр (40 хүртэл км) сумдын сумын төвийн боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин доогуур байгаагаас шалтгаалан тухайн сумын хүүхдүүд ихэвчлэн аймгийн төвийн сургуулиудад суралцах хандлагатай байгаа бөгөөд энэ бүхнээс харахад аймгийн төвтэй ойр сумд нь боловсролын үйлчилгээний үүргээ аймгийн төвдөө алдаж байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Хүн ам олонтой томоохон сумдууд болон аймгийн төвийн сумд руу боловсролын үйлчилгээний таталцал бий болжээ.

Судалгаанд хамрагдсан бүс нутгийн нийт 13-н аймгийн 194 сумдыг хүн амын тоогоор нь ангилахад нийт сумдын 6,07 хувь нь 1500 хүртэл хүн амтай, 40,72 хувь нь 1501-3000 хүн амтай, 30,92 хувь нь 3001-5000 хүн амтай, 13,40 хувь нь 5001-10000 хүн амтай, 8,24 хувь нь 10001-ээс

дээш хүн амтай гэсэн ангилалд хамрагдсан байна. Харин боловсролын үйлчилгээний хөгжлийн индексийг сумын хүн амын тоогоор ангилсан ангиллаас харахад 10001-ээс дээш хүн амтай нийт сумдын 93,75 хувь нь маш дээгүүр болон дээгүүр ангилалд, 5001-10000 хүн амтай нийт сумдын 30,00 хувь маш дээгүүр болон дээгүүр ангилалд багтаж

байхад 1500 хүртэл хүн амтай сумдын 23,08 хувь нь маш доогуур болон доогуур, 1501-3000 хүн амтай сумдын 27,85 хувь нь мөн дээрх ангилалд багтаж байна. Өөрөөр хэлбэл боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс маш доогуур үзүүлэлттэй бүх сумд нь 5000-аас доош хүн амтай сумдын ангилалд багтаж (Хүснэгт 3) байна.

Хүснэгт 3. Боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс, сумын хүн амын тооны ангиллаар, 2013 он

Сумын хүн амын тоогоор	Маш доогуур (0,000-0,200)		Доогуур (0,201-0,400)		Дундаж (0,401-0,600)		Дээгүүр (0,601-0,800)		Маш дээгүүр (0,801-1,000)		Нийт
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
1500 хүртэл	0	0,00	3	23,08	3	23,08	6	46,15	1	7,69	13
1501-3000	7	8,86	15	18,99	26	32,91	20	25,32	11	13,92	79
3001-5000	5	8,33	9	15,00	28	46,67	14	23,33	4	6,67	60
5001-10000	0	0,00	5	19,23	5	19,23	13	50,00	3	11,54	26
10001-ээс дээш	0	0,00	0	0,00	1	6,25	3	18,75	12	75,00	16

Эх сурвалж: Аймгуудын статистикийн товчоон, 2013

Хүн амын төвлөрөл нь боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин, өрсөлдөх чадварт эерэгээр нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл хүн ам олонтой томоохон сумдууд болон аймгийн төвийн сумд руу хүн ам, зах зээл зэрэг эдийн засгийн болон эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээний таталцал нэгэнт бий болсон байна.

*Хатуу хучилттай зам нь сумын боловсролын үйлчилгээний хөгжилд эерэг болон сөрөг нөлөөллийг үзүүлж байна.*

Судалгаанд хамрагдсан бүс нутгийн нийт 13-н аймгийн 194 сумдыг хатуу хучилттай замаар ангилахад нийт сумдын 28,87 хувь нь сумын төвөөр

дайрсан хатуу хучилттай замтай, 17,01 хувь нь хатуу хучилттай зам нутгаар нь дайрсан, 42,78 хувь нь хатуу хучилттай зам төвөөр нь болон нутгаар нь дайрсан сумдтай зэргэлдээ, 11,34 хувь нь бусад гэсэн ангилалд багтсан байна. Харин боловсролын үйлчилгээний хөгжлийн индексийг хатуу хучилттай замын ангиллаар ангилахад боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс маш дээгүүр ангилалд хамрагдаж байгаа нийт сумдын 32,14 хувь буюу 18 сум нь хатуу хучилттай сум төвөөр нь дайрсан ангилалд багтаж байгаа ч маш доогуур болон доогуур ангилалд нийт сумдын 21,43 хувь буюу 12 сум хамрагдаж (Хүснэгт 4) байна.

Хүснэгт 4. Боловсролын үйлчилгээний хөгжлийн индекс, хатуу хучилттай замын ангиллаар, 2013 он

Хатуу хучилттай замтай эсэх	Маш доогуур (0,000-0,200)		Доогуур (0,201-0,400)		Дундаж (0,401-0,600)		Дээгүүр (0,601-0,800)		Маш дээгүүр (0,801-1,000)		Нийт
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
Төвөөр дайрсан	1	1,79	11	19,64	14	25,00	12	21,43	18	32,14	56
Нутгаар нь дайрсан	6	18,18	10	30,30	12	36,36	5	15,15	0	0,00	33
Хөрш зэргэлдээх	5	6,02	8	9,64	30	36,14	32	38,55	8	9,64	83
Бусад	0	0,00	3	13,64	7	31,82	8	36,36	4	18,18	22

Эх сурвалж: Аймгуудын статистикийн товчоон, 2013

Хатуу хучилттай зам нь сумдын боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшинд эерэг болон сөрөг нөлөөллийг үзүүлж байна. Тухайлбал: Хатуу хучилттай зам төвөөр нь дайрдаг Төв аймгийн Эрдэнэсант сумын ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалтын бохир жин 94,60 хувьтай,

1-р ангид элсэгчдийн бохир жин 111,43 хувьтай байхад хатуу хучилттай зам төвөөр нь дайрдаг Баянхонгор аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын хамран сургалтын бохир жин 54,61 хувьтай, 1-р ангид элсэгчдийн бохир жин 44,93 хувьтай (Хүснэгт 5) байна.

Хүснэгт 5. Хатуу хучилттай зам төвөөр нь дайрсан зарим сумдын боловсролын үйлчилгээний зарим үзүүлэлт 2010 он, 2013 он

Аймаг, сумын нэр	Хатуу хучилттай замын ангиллаар	ЕБ-ын сургуулийн хамран сургалтын бохир жин			1-р ангид элсэгчдийн хамран сургалтын бохир жин		
		2010 он	2013 он	Зөрүү	2010 он	2013 он	Зөрүү
Төв, Эрдэнэсант	Төвөөр нь	85,39	94,60	9,21	100,00	111,43	11,43
Баянхонгор, Өлзийт	Төвөөр нь	56,64	54,61	-2,03	66,15	44,93	-21,22

Эх сурвалж: Аймгуудын статистикийн товчоон, 2013

Эдгээр үзүүлэлтээс харвал хатуу хучилттай зам төвөөр нь дайрах нь сумдын боловсролын үйлчилгээний хөгжилд эерэг болон сөрөг нөлөөллийг үзүүлж байгаа нь дээрх сумдын жишээн дээрээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл хатуу хучилттай зам нь тухайн сумдын боловсролын үйлчилгээний хөгжилд эерэг нөлөөг үзүүлж байгаа ч зарим талаар сөрөг үр дагаврыг бий болгож байна.

### ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэснээр өмнө тавьсан судалгааны зорилгодоо хүрсэн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл боловсролын үйлчилгээний хөгжлийн нутаг дэвсгэрийн ялгааг илрүүлэх нэгдсэн индекс тооцох аргазүйг боловсруулж, боловсруулсан аргазүйгээрээ Монгол орны төв хэсгийн 13-н аймгийн 194 сумдын боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшинг тогтоож, нутаг дэвсгэрийн ялгааг илрүүлсэн. Мөн боловсролын үйлчилгээний хөгжлийн нутаг дэвсгэрийн ялгааг илрүүлсний үндсэн дээр түүнд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийн нөлөөллийг судалж дараахь дүгнэлтүүдэд хүрлээ.

- Аймгийн төвтэй ойр (40 хүртэл км зайтай) сумдын сумдын төвийн боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин доогуур байгаа бөгөөд боловсролын үйлчилгээний үүргээ аймгийн төвдөө алдаж байна.
- Хүн ам олонтой томоохон сумдууд болон аймгийн төвийн сумд руу хүн

ам, зах зээл зэрэг эдийн засгийн болон эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээний таталцал нэгэнт бий болсон байна.

- Хатуу хучилттай зам нь тухайн сумдын боловсролын үйлчилгээний хөгжилд эерэг нөлөөг үзүүлж байгаа ч зарим талаар сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Ер нь боловсролын үйлчилгээний хөгжлийн түвшин нутаг дэвсгэрийн хувьд харилцан адилгүй байх нь гарцаагүй бөгөөд хүн амын төвлөрөл, томоохон суурингуудын таталцал, зам тээврийн боломж зэргийг харгалзан боловсролын үйлчилгээний төвүүдийг эрэмбэлж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлсны үндсэн дээр цаашид улам бэхжүүлэн хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- [1]. “Монгол улсын хүний хөгжлийн илтгэл”, 2014 он, Улаанбаатар
- [2]. БШУЯ, “Боловсролын салбарын статистик мэдээллийн эмхтгэл”, 2013 он, Улаанбаатар
- [3]. Д.Доржготов, С.Энх-Амгалан, “Газарзүйн хүрээлэн 50 жил”, 2012 он, Улаанбаатар
- [4]. М.Баянтөр ба бусад, “Газарзүй III” сурах бичиг, 2011 он, Улаанбаатар
- [5]. ҮСХ, “Боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”, 2013 он, Улаанбаатар
- [6]. С. Гэрэлээ “Ерөнхий боловсролын сургуулийн зохистой байршилтын зарим асуудал”, МОГЗА №20, 1982 он
- [7]. Нийгэм эдийн засгийн газарзүйн сектор, “Монгол улсын нийгэм, эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх газарзүйн үндэслэл” 2008-2010 оны сэдэвт ажлын тайлан